

Б. Лхагваа\*

Хүйтэн дайны үеийг төгсгөснөөр түгшүүртэй байдлыг бодитойгоор намжаан зөөлрүүлж, улс түмний харилцаанд харилцан ойлголцох, итгэлцэх, хамтран ажиллах шинэ үеийг нээсэн их өөрчлөлт бусад бүс нутгийн нэгэн адил Зүүн Хойд Ази түүний дотор Солонгосын Хойгийг хамарч байна. Үүнийг дараахь хоёр томоохон чиглэлээр авч үзэж болохоор байна. **Нэгд**, тус хойгийн гадаад нөхцөл байдал; **хоёрт**, дотоод байдал буюу солонгосын хоёр хэсгийн хоорондын харилцаанд гарч буй өөрчлөлт.

#### Нэг. Гадаад нөхцөл байдал

Солонгосын хойгт оршин тогтнож буй хоёр улсын гадаад улс төрийн бодлогод болон бусад орнуудаас БНСУ, БНАСАУ-тай харилцах харилцаанд цоо шинэ өөрчлөлт орж энэ нь ах дүүс өөр хоорондоо цус урсгасан 3 жилийн дайн дэгдээхэд хүргэсэн түгшүүртэй байдал 40 гаруй жил үргэлжилснийг намжаан зөөлрүүлэхэд ямар нэг хэмжээгээр нөлөөлснөөр үл барам дэлхий дахины байдлыг өөдрөгөөр үнэлэх үүднээс бол солонгосын хоёр хэсгийн өөр хоорондын хэлхээ холбоог ойртуулах олон улсын таатай нөхцөл бүрдүүлж эхлэв.

Бүрэлдэн бий болсон энэхүү таатай нөхцөлийг солонгосын асуудлыг шийдвэрлэхэд ухаалгаар оновчтой ашиглахын хамт энэ өөрчлөлтийн урсгалтай хөл нийлүүлэх чиглэлээр солонгосчуудын өөрсдийнх нь зүгээс явуулж буй шинэлэг цогцолбор арга хэмжээ тус хойг түүний эргэн тойронд гарч буй энэхүү өөрчлөлтийн чухал хүчин зүйлийн нэг болж байна. БНСУ-ын Ерөнхийлөгч Ро Дэ У-гийн 1988 оны долдугаар сарын 7-нд зарлан тунхагласан тусгай тунхаглал, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээнд энэ нь тодорхой тусгалаа болсон юм. БНАСАУ ч өөрийн байр суурийн дагуу зарим санал, санаачилга дэвшүүлж байна. Нэг талаас олон улсын харилцаанд гарсан өөрчлөлт, нөгөө талаас БНСУ-ын хүчин чармайлтын дунд 1988 онд болсон Сеулийн олимпын тоглолтод социалист орнуудын ихэнх нь оролцоод зогсохгүй нийгмийн тийм байгуулалтай Зүүн Европын орнуудаас Унгар 1988 онд, Азиас БНМАУ 1990 онд эхэлснээр одоо нэлээд нь БНСУ-тай дипломат болон консулын харилцаа тогтоож, төрийн харилцаагүй зарим нь худалдаа, эдийн засгийн хэлхээ холбоотой байна. Эдгээр орнууд болон БНСУ-ын харилцааны нэг онцлог шинж гэвэл харьцангуй богино хугацаанд төрөл бүрийн салбарыг хамарч идэвхтэй байдлаар өрнөж буй явдал юм.

БНАСАУ энэ шинэ хандлагыг мэдээж талархан сайшааж угтаагүй боловч тэдгээр орнуудтай тогтоосон уламжлалт харилцаагаа таслан зогсоох хүртэл огцом эргэлт хийгээгүй нь цаг үеийн бодит байдлыг харгалзан үзсэний илрэл төдийгүй Японтой харилцаагаа хэвийн болгож төрийн харилцаа тогтоох чиглэл баримталж. АНУ-тай хоёр талын уулзалт хэлцээ хийж байгаа нь тус улсын гадаад боллогод гарч буй өөрчлөлт, шинэлэг хандлагын жишээ мөн. Эх нутаг, үндэстнээ нэгтгэх шилжилтийн шатанд «харилцан хүлээн зөвшөөрөх үүднээс БНАСАУ—АНУ, Японы энэ харилцаанд БНСУ ч хориг саад хийхгүй байна.

\*—Б. Лхагваа Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Солонгосын хойгийн асуудалд түүхийн үүднээс холбогдох холбоо, гүйцэтгэх үүрэг, нөлөөлөх нөлөө болон хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны эзлэх хувийн жин түүнчлэн дээрх «харилцан хүлээн зөвшөөрөх» хувилбар зэргээс үзэхэд БНСУ-ЗХУ, БНХАУ, БНАСАУ,-АНУ, Японы харилцаа тус хойгийн эргэн тойрны гадаад улс төрийн байдлын өөрчлөлтийн өрнөлд чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэхдээ энэ нь дээр дурдсанаас бусад улс орнуудаас БНСУ, БНАСАУ-тай харилцах харилцаа мөн энэ өөрчлөлтийн нэг бүрэлдэхүүн хэсэг болж түүнд түлхэц өгч буй ач холбогдлыг үгүйсгэж байгаа хэрэг огтхон ч биш ээ.

**БНСУ, ЗХУ-ын харилцаа.** М. С. Горбачев 1988 оны есдүгээр сарын 16-нд Красноярскт хэлсэн үгэндээ дэвшүүлсэн санаачилга ЗХУ, БНСУ-ын харилцааг хэвийн болгон сайжруулах бодит эхлэл болсон юм. Үүний дараахан шууд худалдаа нэмэгдэн салбар нэгдэл, пүүсийн хэлхээ холбоо өргөжиж 1989 оны дөрөвдүгээр сард худалдааны төлөөлөгчийн газруудаа Сеул, Москвад нээж зөвлөлтийн тал БНСУ-аас эдийн засгийн групп төлөөлөгчид урьж хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны комисс байгуулах, Находкад БНСУ-ын худалдааны төлөөлөгчийн газар нээх, Сибирьт мод боловсруулах үйлдвэр хамтран барих, өтгөрүүлсэн уран худалдах, иргэний агаарын тээврийн шугам нээх, Сахалинд оршин суугаа солонгос иргэдийн асуудлаар хэлэлцээ хийх санал тавьж энэ нь хэрэгжиж эхэлснээр тус хоёр орны хэлхээ холбоо, хамтын ажиллагаа шуудрах шатандаа орсон байна. 1990 оны гуравдугаар сард консулын газруудаа харилцан нээж улмаар мөн оны зургадугаар сард Сан-Францискод хоёр орны дээд хэмжээний уулзалт болж есдүгээр сард ЭСЯ-ны хэмжээнд дипломат харилцаа тогтоожээ. Түүнчлэн дээд хэмжээний уулзалтаас хойш 6 сарын дараа БНСУ-ын Ерөнхийлөгч Ро Дэ Ё ЗХУ-д айлчилж хоёр орны харилцааны ерөнхий зарчмын тухай тунхаглалд гарын үсэг зурж, энэ үеэр засгийн газрын хооронд хэд хэдэн хэлэлцээр байгуулагдсанаар, харилцаа, хамтын ажиллагааны улс төр, хууль эрхийн үндэс бүрдэв. Ерөнхийлөгч М. С. Горбачев, Ерөнхийлөгч Ро Дэ Ё нарын энэ оны дөрөвдүгээр сарын Чэжү аралд болсон уулзалт хурдацтай явагдаж буй энэ харилцаанд чухал түлхэц өглөө. Ро Дэ Ё ерөнхийлөгчөөр сонгогдсоноос (1988 он) хойших таван жилд хоёр орны худалдааны хэмжээ 10 миллиард долларт<sup>1</sup> хүрэх төлөвтэйн дээр Сибирь, Алс Дорнод дахь хоёр талын хамтын ажиллагааны цар хүрээ улам өргөжих хандлагатай байна.

ЗХУ, БНСУ-ын эрчимтэй харилцаа ЗХУ, БНАСАУ-ын харилцаанд зарим талаар сөрөг нөлөө үзүүлж буй хэдий ч тус хоёр орны Найрамдлын Гэрээ 1996 оны долдугаар сарын 5 хүртэл аяндаа сунгагдсан нь уламжлалт харилцаандаа бүрэн хохирол учруулах сонирхол аль алинд нь одоогоор байхгүйг харуулж байна.

**БНСУ, БНХАУ-ын харилцаа.** 1989 онд 3 миллиард доллар<sup>2</sup> байсан хоёр талын худалдааны хэмжээ 1995 онд 10 миллиард<sup>3</sup> болж БНХАУ-д оруулах БНСУ-ын хөрөнгө оруулалт 1 миллиард долларт хүрэх төлөвтэй бөгөөд харилцан ирж очиж байгаа хүний тоо 1988 онд гэхэд 10 мянга болон олширчээ. Худалдаа, хүн солилцоо ийнхүү нэмэгдсэн нь худалдааны төлөөлөгчийн газраа (консулын үйл ажиллагаа явуулах эрхтэй) харилцан нээх тохиролцоонд хүргэжээ. Одоогоор төрийн харилцаа тогтоогоогүй байгаа нь БНАСАУ-тай тогтоосон найрамдалт харилцаагаа БНХАУ хүйтрүүлэхээс болгоомжилж буйн зэрэгцээ Солонгосын хойгт хоёр улс оршин тогтнож буйг хүлээн зөвшөөрөх аваас Тайваныг хэрхэх вэ? гэх зэргийн шалтгаантай холбоотой байж болох юм.

Экспортын чиглэлийг хойшид ч голлох БНСУ-ын тухайд эдийн засгийн үүднээс миллиард гаруй хүн амтай том зах зээл, улс төрийн талаас солонгосын асуудлыг шийдвэрлэхэд зохих нөлөө бүхий БНХАУ-тай харилцаагаа өргөжүүлэн улмаар дипломат харилцаа тогтоох бүрэн эрмэлзэлтэй байна. Хэрвээ дипломат харилцаа тогтоочихвол БНСУ гадаад бодлогынхоо ойрын зорилтынхоо гол үндэс суурийг бүрдүүлээ гэж үзэх байх.

Эдийн засгийн сонирхлын үүднээс БНСУ-тай БНХАУ харилцаагаа хойшид ч үргэлжлүүлэн хөгжүүлнэ. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд БНМАУ, БНСУ-ыг өөрийн нутаг дэвсгэр дээгүүрээ дамжуулан иргэний агаарын тээврийн шугамаар холбох боломжийг БНХАУ олговол энэ нь Азийн том гүрний хувьд хөрш зэргэлдээ орнууддаа хамтын ажиллагааны таатай нөхцөл бүрдүүлэх сайн санааны тус дэмжлэг болохсон билээ.

**БНАСАУ, Японы харилцаа.** Дам болон шууд хэлбэрээр худалдаа хийж, албаны хүмүүс харилцан үе үе ирж очилцож байсан БНАСАУ, Японы хооронд 1990 оноос улс төрийн харилцаагаа хэвийн болгохтой холбогдсон асуудлаар яриа хэлэлцээ хийгдэх болсноор энэ хоёр орны хооронд дипломат харилцаа тогтох боломж бий болж магадгүй байна. Гэхдээ Японы хувьд БНСУ, АНУ-тай харилцах харилцаагаа харгалзан үзэх шаардлагатай байгаа бололтой.

**БНАСАУ, АНУ.** 1988 оны арваннэгдүгээр сараас Бээжин дэх хоёр орны ЭСЯ-ны улс төрийн зөвлөх нарын хэмжээнд эхэлсэн уулзалт яриа 15 удаа болоод байна. АНУ-ын зарим эрдэмтэд, улс төрийн албаны түшмэд БНАСАУ-д, 1988 оноос хойш БНАСАУ-ын хэд хэдэн групп төлөөлөгчид АНУ-д зочилж, солонгосын дайнд амь үрэгдсэн америк цэргүүдийнхээс 5 хүний шарилыг шилжүүлж өгсөн зэрэг нь ийм уулзалт яриа хийхэд түлхэц өгсөн бололтой.

Дээрх уулзалт ярианы талаар тодорхой мэдээлэхгүй байгаа боловч БНАСАУ-ын тал АНУ-тай шууд яриа хэлэлцээ хийж харилцаагаа сайжруулах, солонгосын дайны гал зогсоосон хэлэлцээрийг энх тайвны хэлэлцээр болгон өөрчлөх, америкийн цэргийг гаргах «Тим—спирит» цэргийн сургуулийг зогсоох, солонгосын дайнд амь үрэгдсэн америкийн цэргийн шарилыг шилжүүлэх асуудлаар засгийн газрын хоорондын тохиролцоонд хүрэх; америкийн тал солонгосын хоёр хэсгийн хэлхээ холбоо, яриа хэлэлцээг урагшлуулах, 38-р өргөрөгийн дагуух цэрэггүй бүсийн районд итгэлцлийн найдвартай баталгаат механизм бүрдүүлэх, амь үрэгдсэн америк цэргүүдийн шарилыг авахтай холбогдсон асуудал голлон хэлэлцэж, БНАСАУ-ын цөмийн төхөөрөмжүүдийг олон улсын хяналтанд оруулахыг АНУ шаардаж байгаа тухай мэдээ байна. БНАСАУ-тай харилцаагаа яаравчлан сайжруулах талаар АНУ төдийлөн яарахгүй байгаа нь үүнээс гарах эцсийн ашиг бага гэж үзэж буйтай холбоотой байж болохоос гадна дээрх урьдчилсан нөхцөлүүдийг БНАСАУ хэрхэн хангах, солонгосын хойгийн байдал цаашид яаж өрнөхийг харзнаж хурдацыг нь тохируулах байр суурь баримталж буйтай холбоотой болов уу.

#### Хоёр. Дотоод хүчин зүйл

Хуваагдмал эх нутаг, үндэстнээ нэгтгэхэд чиглэсэн БНАСАУ, БНСУ-ын өөр хоорондынх нь харилцан ажиллагаа, хамтын хүч чармайлт бол солонгосын асуудлыг шийдвэрлэх дотоод хүчин зүйл мөн. Сүүлийн жилүүдэд энэ чиглэлээр хоёр тал идэвхтэй санаачилга гаргаж, байр сууринд нь мэдэгдэхүйц өөрчлөлт гарч түүний зарим нь биеллээ олж байна. Ялангуяа БНСУ-ын Ерөнхийлөгч Ро Дэ Ё 1988

1989, 1990 онд удаа дараагийн тунхаглал, мэдэгдэлдээ хоёр тал өрсөлдөх, сөргөлдөх, дайсагналцах байдлаас итгэлцэх, эвлэрэх, хамтран ажиллах түүний дотор өөр хоорондоо үүд хаалгаа чөлөөтэй нээн төрөл бүрийн салбарт өргөн хэлхээ холбоо тогтоох, нийт үндэснийхээ нийтлэг эрх ашгийн төлөө дотоод, гадаад бодлогын хүрээнд хамтран ажиллах улмаар эх нутаг, үндэстнээ нэгтгэх шинэлэг санал, санаачилга дэвшүүлж, БНСУ түүнийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ авав. Мөн БНАСАУ-ын Ерөнхийлөгч, СХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ким Ир Сенний хэлсэн үг, ярилцлагад агуулагдсан санал, түүний дагуу хийсэн БНАСАУ-ын алхмуудыг ч бас тэмдэглэх хэрэгтэй юм.

Эх нутаг, үндэстнээ нэгтгэх хоёр талын байр суурийн тухайд гэвэл: БНАСАУ гаднын хүчний оролцоогүйгээр бие дааж, энх тайван замаар, үзэл суртал, ойлголт, нийгмийн байгууллын ялгааг гэтлэн давж үндэсний их эв нэгдлийг хангах аргаар; БНСУ ч мөн бие дааж, энх тайван замаар ардчиллын аргаар хэрэгжүүлэх чиг шугам баримталж байна. Нэгтгэх зарчмын энэ асуудлаархи хоёр талын байр сууринд ноцтой зөрөө бараг алга гэж үзэж болохоор байна. Мөн нэгдсэн төр улсаа ямар байдлаар хэрхэн төвхнүүлэхийн хувьд БНАСАУ «Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Корё Улс байгуулах, БНСУ «Нэгдмэл Ардчилсан Бүгд Найрамдах Улс» байгуулах хэтийн зорилтын үүднээс шилжилтийн арга хэмжээ болгож «нэг үндэстэн хоёр улс» гэсэн холбооны маягийн «Солонгос үндэстний хамтын нийгэмлэг» байгуулах санал дэвшүүлж байгаа бөгөөд харин түүнийг хэрэгжүүлэх арга зам, хэлбэр, шилжилтийн үе шат, энэ үед авах арга хэмжээ, нэгдмэл улс байгуулсны дараахь ирээдүйн чиг баримжаа зэрэг асуудлаар харилцан адилгүй байр суурьтай байна.

Гэхдээ сүүлийн үед хоёр тал байр сууриа зарим талаар ойртуулах, харилцан хүлээн авч болохуйцаар асуудлыг дахин хянан үзэх, яриа хэлэлцээг үргэлжлүүлэх, харилцан ойлголцох, зарим салбарт хэлхээ холбоогоо бэхжүүлэх зэрэг чиглэлд нэлээд шинэлэг хандлага, өөрчлөлт гаргаж байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, БНАСАУ Хоёр талын хооронд улс төр, цэргийн асуудлыг шийдвэрлэсний дараа бусад салбарын асуудлыг авч үзэх, БНСУ түүний эсрэг улс төр, цэргийн бус хүрээнд хэлхээ холбоо, хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлэх замаар итгэлцлийн уур амьсгал бүрдүүлсний үндсэн дээр улс төр, цэргийн асуудлыг шийдвэрлэх ёстой гэдэг шаардлага аль аль нь хянан үзэж улс төр, цэргийн салбар, түүнээс бусад хүрээний асуудлыг зэрэгцүүлэн авч үзэх болсныг улс төрийн шинжтэй ерөнхий сайд нарын уулзалт, харьцангуйгаар идэвхтэй өрнөж буй улс төрийн бус хүрээний хэлхээ холбоо, яриа хэлэлцээ тодорхой харуулж байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн яриа хэлэлцээ хийхийг зөвшөөрсөн нь БНСУ-ын байр сууринд, улс төрийн бус хүрээний хэлхээ холбоо тогтооход хүрсэн нь БНАСАУ-ын байр сууринд гарч буй томоохон өөрчлөлт төдийгүй хойгийн эргэн тойрны, цаашлаад олон улсын харилцаанд өрнөж буй өөрчлөлтийн их урсгалтай хөл нийлүүлэх гэсэн хоёулангийнх нь нэгдсэн эрмэлзлэлийн бодит илрэл мөн гэж үзэлтэй.

Үүнээс гадна ерөнхий сайд нарын уулзалтын үеэр болон түүнээс өмнө БНАСАУ-ын тавьж байсан засгийн газрын зөвшөөрөлгүйгээр БНАСАУ-д зочилсон Мун Ик Хван ламтан, Пхеньянд болсон дэлхийн залуучууд оюутны их наадамд оролцсон Им Сү Ген нарын улс төрийн хоригдлуудыг суллах, БНСУ, АНУ-ын «Тим-спирит» цэргийн хамтарсан сургуулийг зогсоох буюу хэмжээг нь багасгах, НҮБ-д дангаараа эсвэл зэрэг орохоос татгалзах, «харилцан үл довтолох тухай тунхаг-

лал» гаргах зэрэг шаардлагуудын дотроос НҮБ-д элсэн орохоос бусад асуудалд БНСУ нааштай хандан Мун Ик Хван ламтанг сулласны дээр «Тим спирит» цэргийн сургуульд АНУ дахь цэргийн баазаас энэ жил цэрэг дайчлан оролцуулахгүй байх, өмнөд, умард хэсгийн хооронд хүч үл хэрэглэхийн хувьд БНАСАУ-тай адилхан байр суурьтай, үүнийгээ нотлон «Өмнөд умардын хооронд харилцан үл довтлох тухай хэлэлцээр»<sup>4</sup> байгуулах санал дэвшүүлж байсан боловч БНАСАУ-ын «харилцан үл довтлох тухай тунхаглал»-ыг нэр томьёоны хувьд зөвшөөрөх мэдээ байна.

Хэрвээ хоёр тал хүч үл хэрэглэх, харилцан үл довтлох тохиролцоонд хүрвэл энэ нь улс төрийн асуудлыг эхэлж шийдвэрлэх БНАСАУ-ын саналыг БНСУ хүлээн зөвшөөрсөн хэрэг төдийгүй тус хойгийн байдлыг намжаан зөөлрүүлэх, харилцан итгэлцэх уур амьсгал бүрдүүлж бэхжүүлэхэд тус дөхөм болох нь дамжиггүй. Нэр томьёоны хувьд тунхаглал, хэлэлцээр, гэрээ аль нь ч бай хамгийн гол нь түүнийг сахин мөрдөх найдвартай баталгаа бий болгох нь юу юунаас чухал гэдгийг улс орнуудын харилцаанд зарим үед гарч байсан түүхэн золгүй сургамж сануулж буй бөлгөө.

Эх нутаг, үндэстнээ нэгтгэх хүртэлх шилжилтийн үед хоёр тал бие биенийхээ нийгмийн системийг харилцан хүлээн зөвшөөрөх, аль нэг талынхаа эсрэг хорлон сүйтгэх, засаг төрийг нь түлхэн унагах ямарваа оролдлого хийхгүй байх, НҮБ-д нэгэн зэрэг эсвэл дангаараа элсэн орох, дэлхийн бүхий л улс орнуудтай «харилцан хүлээн зөвшөөрүүлэх» хэлбэрээр харилцаа тогтоох тухай БНСУ-ын саналуудын заримд нь БНАСАУ нааштай хандах байдал ажиглагдаж байна. Японтой харилцаагаа хэвийн болгож төрийн харилцаа тогтоох чиглэлээр хийж буй БНАСАУ-ын алхам үүний нэг илрэл юм. Мөн НҮБ-д тус тусдаа бие дааж орж ч магадгүй байна. Хэрвээ БНАСАУ энэ талаархи урьдын байр сууриа хадгалвал БНСУ бие дааж орох асуудлыг энэ онд тавих төлөвтэй байгаа бөгөөд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн АНУ, ЗХУ, Англи, Франц болон НҮБ-ийн олонхи гишүүн орнууд дэмжих бололтой. Харин НҮБ-ын-Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн БНХАУ хэрхэн хандах нь сонирхол татаж байгаа бөгөөд солонгосын асуудалд хандах дэлхийн дийлэнх орны хандлага, БНСУ-ын идэвхтэй дипломат үйл ажиллагаа, олон улсын үйл амьдралд тус улсын гүйцэтгэж буй үүрэг, оролцоо, байр суурь, БНХАУ, БНСУ-ын харилцаа, түүхийн хэтийн төлөв зэргээс үзэхэд БНХАУ шууд татгалзах нь тохиромжгүй, харин түдгэлзэх болов уу гэсэн таамаглал хийж болох байна.

Бэлтгэл уулзалтуудын дүнд 1990 онд Сеул, Пхеньянд ээлжлэн болсон хоёр талын ерөнхий сайд нарын гурван удаагийн уулзалт улс төрийн хүрээн дэх хэлхээ холбоонд чухал үйл явдал болов. Хэлэлцээний явцад БНСУ эх нутаг, үндэстнээ нэгтгэх хүртэлх шилжилтийн хугацаанд хоёр тал бие биенийхээ нийгмийн байгууллыг хүлээн зөвшөөрөх; хоёр талаа шүүмжлэн гүтгэх улс төрийн суртал ухуулгаа зогсоож, дотоод хэрэгт оролцохгүй байх; маргаантай бүх асуудлыг яриа хэлэлцээний аргаар энх тайван замаар шийдвэрлэх; дайсагнах, хорлон сүйтгэх ажиллагаа явуулахгүй байх; ард иргэдийг чөлөөтэй ирж очуулан тэдний хоорондын хэлхээ холбоог тал бүрээр хөхүүлэн дэмжиж хамтран ажиллах; зэвсэглэлээр хөөцөлдөхийг хязгаарлан цэргийн салбарт итгэлцлийг бэхжүүлэх арга зам эрэлхийлж зэвсэгт хүчнээ хорогдуулах; олон улсын талбарт өрсөлдөн сөргөлдөхийг хязгаарлан багасгаж хамтран ажиллах зэрэг саналууд тавьсан байна. Үүнээс гадна нэгтгэх зарчим, арга замын талаархи үндсэн чиг шугамаа тайлбар-

лаж «Өмнөд, умардын харилцааг сайжруулах үндсэн тохиролцоо»-нд хүрэхэд чиглэсэн нэмэлт саналууд дэвшүүлжээ.

БНАСАУ хэлэлцээний явцад эх орон, үндэстнээ нэгтгэх талаар 1912 оны гуравдугаар сарын 4-нд хоёр талын тохиролцсон 3 зүйлт зарчмыг дахин нотлох; аль нэг талын бус үндэстний нийтлэг эрх ашигт нийцсэн асуудлуудыг хэлэлцэн тохиролцох; хэлэлцээг урагшлуулж амжилтад хүргэхэд саад тотгор учруулах аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулахгүй байх; харилцан үл довтолох тухай тунхаглал гаргах асуудлаар яаралтай тохиролцоонд хүрэх, үндэстний эв нэгдэл, эх орноо нэгтгэхэд үл нийцэх хууль ёсны хийгээд нийгмийн шинжтэй бүх үйлдлүүдийг зогсоох, нөгөө талаа сурталчлан таниулах, үзэл санааг нь итгэн дагах эрх чөлөөгөөр хангах, улс төрийн намууд, олон нийтийн байгууллага, янз бүрийн анги давхрагынхан өөр хоорондоо чөлөөтэй харилцахыг зөвшөөрөх гэх зэргийн санал дэвшүүлсэн ажээ.

Одоогоор тодорхой амжилт, дорвитой тохиролцоонд хүрсэн эсэх нь мэдэгдэхгүй байгаа боловч анх удаа ийм өндөр хэмжээнд уулзаж байгаагаараа, 1970-аад онд эхлээд зогссон хоёр талын иймэрхүү уулзалтыг сэргээн үргэлжлүүлж түүний зэрэг зиндааг ахиулснаараа, улс төрийн болон улс төрийн бус салбарт хэлхээ холбоо тогтоох, тогтоосноор үргэлжлүүлэхэд түлхэц өгснөөрөө, байр сууриа харилцан тайлбарлаж зарим тодорхой санал санаачилга гаргаснаараа, магад ч үгүй дээд хэмжээний уулзалт хийх угтвар нөхцөл бүрдүүлснээрээ эдгээр уулзалт ихээхэн ач холбогдолтой юм.

Ерөнхийлөгч Ро Дэ Ё 1988 онд «Эх орон нэгтэн 60 сая иргэдийнхээ хүсэл эрмэлзлийн дагуу үндэстний нэгдлийг бодитойгоор хэрэгжүүлэх зорилгоор аль болох ойрын үед уулзаж хэлэлцээ хийхийг Ерөнхийлөгч Ким Ир Сенд санал»<sup>5</sup> болгосон, 1990 онд хоёр талын ерөнхий сайд нарын уулзалт-хэлэлцээнд оролцсон БНСУ-ын ерөнхий сайд Кан Ен Хунийг Ерөнхийлөгч Ким Ир Сен хүлээж авахдаа: «Ерөнхий сайд нарын уулзалтаар намайг болон Ерөнхийлөгч Ро Дэ Ё-г уулзуулах боломж бүрдүүлнэ гэдэгт найдаж»<sup>6</sup> байна гэсний гадна уг уулзалтад оролцогсод, засгийн газар, ерөнхийлөгчийн ойр дотны хүрээнийхний хэлсэн үг, ярилцлагаас үзэхэд хоёр талын дээд хэмжээний уулзалт хэрэгжих төлөв нээгдэж магадгүй байна. Хэрвээ хоёр талын хэлхээ холбоо идэвхтэй үргэлжилж, нөхцөл боломжоо сайтар ашиглан, тус хойгийн гадаад байдал ийм уулзалт хийхэд таатай байдлаар нөлөөлбөл энэ онд багтаж ч болох юм. Ийм уулзалт болох эсэх, болвоос хир зэрэг ойрын үед хийгдэх нь хоёр талын хүчин чармайлтаас шууд шалтгаалах нь тодорхой.

Мөн хоёр талын парламентын төлөөлөгчдийн бэлтгэл уулзалт 1990 оны дундуур сэргэн үргэлжилж Пхеньянд энэ онд (1991 онд) болсон Олон улсын парламентын Холбооны хаврын чуулганд БНСУ-ын парламентын төлөөлөгчид оролцохыг БНАСАУ зөвшөөрч, хоёр талын боловсролын байгууллагын эрх баригчдын уулзалт хийх, 1986 онд тасарсан улаан загалмайн нийгэмлэгийн төлөөлөгчдийн уулзалтыг сэргээх тухай саналын зарим нь хэрэгжиж байна.

Хоёр талын харилцаанд сүүлийн жилүүдэд гарч буй өөр нэг шинэлэг зүйл бол худалдаа, эдийн засгийн салбар дахь хэлхээ холбоо юм. БНАСАУ-тай худалдаа, эдийн засгийн салбарт харилцах, хамтран ажиллах нээлттэй бодлого баримтлахыг БНСУ 1988 оны аравдугаар сард зарласан явдал үүнд зохих нөлөө үзүүлэв. Үүний дагуу БНАСАУ-ын яармаг худалдаа БНСУ-д нээгдэж, хоёр талын худалдаа өсөх хандлагатай болов. 1988 оны аравдугаар сараас 1990 оны долдугаар сард БНАСАУ 56 нэр төрлийн 29 сая 689 мянган долларын бүтээгдэ-

хүүн БНСУ-д экспортлож, БНСУ 152 мянган долларын бараа БНАСАУ-д гаргажээ.<sup>7</sup> БНАСАУ-аас БНСУ-д нийлүүлсэн барааны голыг өргөн хэрэглээнийх эзэлж байснаа сүүлийн үед төмрийн хүдэр зэрэг аж үйлдвэрийн эрдэс түүхий эд голлон нэр төрөл нь олшрох болсны дээр өмнө нь гуравдахь орноор дамжуулж худалдаа хийдэг хэлбэрээ шууд хэлбэрт оруулах хандлагатай байгаа нь энэ салбар дахь харилцааны онцлог шинж болж байна. БНАСАУ-ын иргэний агаарын болон далайн тээврийн хөлөг онгоц, бараа таваарыг БНСУ-д хязгаарлалтгүй оруулж байхыг БНСУ 1990 оны зургадугаар сард зөвшөөрөв. Хэрэгцээ, шаардлага, тохиромж таарамж, тээвэр, газар зүйн байрлал зэрэг аль ч талаас нь аваад үзсэн нэг үндэстэн өөр хоорондоо худалдаа, эдийн засгийн харилцаагаа өргөтгөх нь нийт солонгос үндэстний эрх ашигт нийцэх нь дамжиггүй.

Анхаарал татаж буй бас нэг сонин өөрчлөлт гэвэл спорт, урлаг, соёлын салбарыг голлосон улс төр, цэрэг, эдийн засгийн бус хүрээн дэх хэлхээ холбоо юм. Саяхан болтол санахын аргагүй хатуу хяналттай байсан энэ хэлхээ холбоо хязгаарлагдмал хэдий ч борооны дараахь мөөг мэт хурдацтай эхэлж, жирийн ард иргэд нэгэн үндэстний ёсоор ойртон дотносох болсноороо энэ нь чухал ач холбогдолтой юм. Бээжингийн 1990 оны Азийн XI тоглолтод хоёр талаасаа оролцогсод бие биенийхээ баг-төлөөлөгчдөд баяр хүргэж тэмцээний үеэр аль алиныхаа тамирчныг хамтран дэмжиж цэнгэлдэх хүрээлэнгийн анхаарлыг бүхэлд нь татсан сэтгэл хөдлөм үйл явдал, хөлбөмбөгийн нэгдмэл багийн тоглолт хийхээр энэ үеэр тохиролцон анхны тоглолтоо Азийн XI тоглолтын дараа бараг шууд 1990 оны 10 дугаар сарын 11-нд Пхеньянд, дараагийнхыг мөн сарын 23-нд Сеулд хийж түүнийг залгуулан 1990 оны 11 дүгээр сарын 29-нд хоёр талын биеийн тамирын байгууллагын төлөөлөгчдийн хэлэлцээ болж 1991 оны 4 дүгээр сарын одон бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (Японд болсон), 1992 оны олимп болон бусад зарим тэмцээн тоглолтод нэгдмэл багаар оролцож, хөл бөмбөгийн хамтарсан тоглолтоо тогтмол хийж байхаар тохиролцсон бололтой. Уг тохиролцоо ёсоор энэ оны 4-р сард Японд болсон одон бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд хоёр тал солонгосын хойгийн газрын зураг бүхий таних тэмдэгтэй «Корея» нэртэй нэгдмэл багаар оролцлоо. Үүнээс гадна хоёр талын кино жүжигчид оролцсон хамтарсан анхны кино үзвэр Нью Йоркт, БНСУ-ын 14 хөгжимчин оролцсон хамтарсан тоглолт Пхеньянд болж ойрын үед «Өмнөд, умардын хөгжмийн хамтлаг» байгуулахаар уг тоглолтод оролцогсод тохиролцсон мэдээ байна,

Биеийн тамир, соёл урлагийн солилцоо, хэлхээ холбоо бусад салбарынхаас ийнхүү илүү эрч хүчтэй, өргөжих хандлагатай, бие биенийгээ урихаар үл барам хамтарч оролцох хэлбэрт аль хэдийн шилжиж аль аль талынх нь олон нийт үүнийг талархан дэмжиж байгаагаараа энэ нь ард түмний жинхэнэ амьд бодитой хэлхээ холбоо, хамтын ажиллагаа болж байна. Энэ шинж чанараараа хуваагдмал үндэстнээ ойртуулан нэгтгэх найдвартай хөрс суурийг бүрдүүлэхэд тус дөхөм үзүүлж чадах бөгөөд үе үе тасалдсан ч гэсэн ирээдүйтэй байж болох юм.

Ерөнхийлөгч Ким Ир Сен 1990 оны шинэ жилийн мэндчилгээний болон мөн оны тавдугаар сард хэлсэн үгэндээ хоёр талын иргэдийг чөлөөтэй ирж очуулах, Панмунжомын умард хэсгийн районыг үүнд зориулж чөлөөлөгдсөний өдөр 8-р сарын 15-наас нээх тухай мэдэгдсэнийг Ерөнхийлөгч Ро Дэ Ё тодотгож 1990 оны 7-р сарын 20-нд гаргасан тунхаглалдаа мөн оны 8-р сарын 13-наас эхлэн 5 өдөр Панмунжомоор дамжуулж умард хэсгийн иргэдийг хязгаарлалтгүй хүлээн авч

БНСУ-ын хүссэн газраар нь зочлуулах, умард тал зөвхөн Панмунжомын районоор хязгаарлахгүйгээр өмнөд талын иргэдэд мөн ийм бололцоо олгох, умард тал энэ саналыг хүлээж авахгүй ч гэсэн өөрийн талын энэ шийдвэрээ хүчин төгөлдөр байлгах тухайгаа зарлав. Гэвч БНАСАУ цэрэггүй бүсийн дагуу барьсан бетонон хэрмийг буулгах, улсын аюулгүй байдлын тухай хуулиа цуцлахыг шаардсан болзлыг БНСУ-д тавьснаар дээрх санал үндсэндээ хэрэгжсэнгүй. Харин хилийн чанадад амьдардаг солонгос иргэдээс хоёр талд зочлогчид нэмэгдэх төлөвтэй байна. Ер нь хоёр талаас Панмунжомоор дамжин иргэд харилцан ирж очсон явдал огт байхгүй гэвэл тийм бишээ. 1985 оны есдүгээр сард салж тусгаарлагдсан төрөл төрөгсөд, урлагийн хэсэг 150-иад хүн харилцан зочилсон удаа бий. Германыг нэгтгэсэн хэлбэрийг Солонгост тэр аяар нь хуулбарлан хэрэглэж болохгүй нь мэдээж боловч хуваагдмал нөхцөл дэх иргэдийн хоорондын харилцаа, хэлхээ холбооны талаархи тэдний жишээг бүрэн үгүйсгэх нь утгагүй хэрэг болно биз ээ. Тэр тусмаа нэгдэх хүсэл эрмэлзэл илүү хүчтэй солонгосын нөхцөлд ард иргэд нэн ялангуяа салж сарнисан 10 сая төрөл төрөгсдийг уулзуулж иргэдийн харилцааны хамгийн наад захын нөхцөлийг хангаж өгөх нь зайлшгүй шаардлага мөн. Энэ үйл явцыг дайрч өнгөрөхгүйгээр үндэстнээ ойртуулан нэгтгэх зорилт өнөө үед хэрэгжих бололцоогүй юм. 1963 оны 12-р сард христосын мэндэлсний ойг тохиолдуулан Берлиний ханыг түр зуур нээж, түүнд хөрслөн ард иргэдийн ирж очилцох явдал үндсээрээ нэмэгдсэн жишээ бий.

БНСУ-ын зүгээс хийж буй өөр нэг шинэ алхам бол БНАСАУ-ыг үл итгэх, ялгаварлан үзэх, муучлах хуучин суртал ухуулгаа өөрчилж харилцан итгэлцэж, хамтран ажиллах замаар цэцэглэн хөгжих ёстой үндэсний хамтын нийгэмлэгийн нэг хэсэг гэсэн ойлголтыг ард түмэндээ төрүүлэх чиглэлээр авч буй шинэ арга хэмжээнүүд юм. Боловсролын байгууллагууд, олон нийт, жирийн ард иргэдийн дунд явуулж буй сургалт, сурталчилгаа, мэдээллийг ийм чиглэлээр засварлаж, БНАСАУ, социалист нийгмийн талаархи хаалттай байсан мэдээллийг ил болгон байдлыг бодитойгоор ойлгуулах, БНАСАУ-ын төвийн зарим хэвлэл, телевизийн нэвтрүүлгээс нь дамжуулах ажлуудыг зохиож буй нь үүний тодорхой баримт мөн.

#### **Гурав. Хэтийн төлөв**

Гадаад, дотоод хүчин зүйл, түүний өрнөлтийн явц солонгосын хоёр хэсэг улам ойртон улмаар нэгдэх боломж бүрдэх өөдрөг найдвар төрүүлж байна. Магад ч үгүй энэ зуундаа багтаж болох юм. Учир нь дэлхий дахины байдал бүхэлдээ нааштайгаар өөрчлөгдөж байна. Асуудлыг шийдвэрлэх улс төрийн хэрэгслээс эдийн засгийнх илүү нөлөө, үр өгөөжтэй болон хувирч буй нь ийм найдвар тавих бас нэг иш үндэс болж байна. Мөн хоёр талын улс төр, цэргийн бус салбар дахь хамтын чармайлт тодорхой үр дүнд хүрч энэ хэлхээ холбоо хурдацтай явагдаж, өргөжих хандлагатай байна. Боломж бүрдсэн цагт асуудлыг аль болохоор түргэн шийдвэрлэхийг ард түмэн хүсэхээр барахгүй шаардах нь мэдээж. Солонгосын нэгдэх энэ үйл явц хоёр талыг хамарсан гэнэтийн огцом өөрчлөлт гарахгүй бол тодорхой үе шат дамжих болов уу.

Гэхдээ олон улсын нөхцөл байдал нэг чиглэлээр байнга тогтвортой үргэлжилнэ гэсэн найдвартай баталгаа бүрэн бий болоогүйгээс гадна солонгосын хойгийн байдалд илүү нөлөө үзүүлж чадах тэдгээр орнуудын байр суурь, үндэсний эрх ашиг харилцан адилгүй байж магадгүй юм. Өнөөгийн нөхцөл байдал солонгосчууд үндэснийхээ асуудлыг шийдвэрлэх түүхэн хамгийн тохиромжтой үе байж ч болох юм.

1. Минжок Жисон Ким Док Жүн. 90 нён-ы намбукхан вэгёженчек-ы пёнка мит женман. Сеул., 1990, № 12, р. 25
2. Мөн тэнд
3. МОНЦАМЭ-гийн мэдээ, 1991, 3, 29, № 72
4. «7. 7. тыкбер сөнөн 2 нён», р. 29
5. Минжок Жисон и Дон Бук «Намбук гоовы хвэдам сенква за ханбандо-ы тон-ыр жөнман» Сеул, 1990, № 12, р. 31
6. Мөн тэнд, р. 31
7. «7. 7. тыкбер сөнөн 2 нён 1990» Гукто-тонырвөн. р. 26

### ӨМНӨД СОЛОНГОС-ТООНЫ ХЭЛЭЭР

Өмнөд Солонгосын газар нутаг 99 мян. км<sup>2</sup> буюу Солонгосын хойгийн нийт нутгийн 45% -ийг эзэлнэ.

1990 онд Өмнөд Солонгосын нийт хүн ам 42 сая 793 мянгад хүрсэн байна. Хот суурин газрын хүн ам 1960 онд 28% байсан бол 1989 онд 73,1% болж нэмэгдсэн байна. Зөвхөн нийслэл Сеул хотод хүн гамын 25% суудаг.

\* \* \*

Өмнөд Солонгосын Үндэсний нийт бүтээгдэхүүн 1989 онд 210 тэрбум америк долларт хүрчээ. Нэг хүнд ноогдох үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээ 1989 онд 4968 америк доллар болсноор Өмнөд Солонгос 5000 мянгын хязгаарыг давсан байна.

\* \* \*

1989 онд нийт тариалангийн талбай 2,12 сая га байснаас усалгаатай нь 1,35 сая га, усалгаагүй талбай 0,77 сая га байжээ. Нэг тариачин өрхөд ноогдох газрын хэмжээ 1,2 га хүрчээ. Сүүний болон махны чиглэлийн үхрийн тоо 1989 онд 2,05 сая байсан бол гахайн тоо 4,8 сая байжээ.

\* \* \*

Өмнөд Солонгос 1989 онд 11 сая 580 мян. өнгөт телевизор, 9 сая 98 мян. видеомагнитофон, 2 сая 803 мянган хөргөгч, 1 сая 864 мян. угаалгын машин үйлдвэрлэсэн байна.

\* \* \*

Өмнөд Солонгосын автомашины үйлдвэрлэл жилээс жилд өргөжин 1989 онд нийт 1 сая 88 мян, машин үйлдвэрлэснээс суудлын тэрэг 846 мянга, ачааны тэрэг 163 мян. автобус 79 мянган ширхэг болжээ.

\*\*\*

1989 онд хотын оршин суугчийн сарын дундаж орлого 804 мян. 938 вонд хүрч нэмэгдсэн байна. Харин тэдний сарын дундаж зардал 631 мян. 281 вон болжээ. Хөдөөгийн хүн амын жилийн дундаж орлого 9 сая 436 мян. вон болж нэмэгдсэн бол дундаж зардал 7 сая 262 мян. вон болжээ.

\* \* \*

Өмнөд Солонгосын экспорт 1989 онд 62,4 тэрбум америк долларт хүрчээ. Үүнд хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүн 53,6%, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн 39,7% хүнс өргөн хэрэглээний бараа 4%, түүхий эд, түлш шатахуун 2,7%-ийг эзэлсэн байна.